# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 02-ний өдөр

Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Зорилт 1. Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна" гэсэн тэргүүлэх зорилт /НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1, ХАХТ-3.1.1.1, 3.1.1.2, 3.1.1.3, 3.1.1.5/ | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 3.4.1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, байгууллагын төлөвлөгөө, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах [1,2] | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилт | 100% | 100% | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2, 6.3 заасан аргачлалын дагуу байгууллагын хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Илтгэх хуудсаар танилцуулан, зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүнд:<br>- *Нийслэлийг 2023 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 57.5%,*<br>- *Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 40 тогтоолын 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн хэрэгжилт 97.6%,*<br>- *Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 8 тогтоолын нэгдүгээр улирлын хэрэгжилт 91.4%,*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 70%,*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2024 оны 20 захирамжийн 23 заалтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 97.9%.* |
| Зорилт 2. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт - Өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шалгалтаар зөрчлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2.1 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлэх ажлыг зохион байгуулах[4] | - | Шалгуур үзүүлэлт боловсруулах төлөвлөгөөний хэрэгжилт | - | 100% | Байгууллагын нийслэлийн төсөвт төвлөрүүлэх нийт орлогын дүнгийн 2016-2023 оны дүн шинжилгээ хийхэд 2023 онд нийт 3,108,508.1 мянган төгрөгийг төвлөрүүлж өмнөх оноос 377,141.8 мянган төгрөгөөр буюу 14%-р бага байна. Өмч хувьчлалын орлого 2017,2018, 2020 онуудад 5.0-20 тэрбум төгрөг байсан бол 2022-2023 онуудад өмч хувьчлал явагдаагүйгээс орлого буурсан байна. Түрээсийн орлого 2016 онд 1.6 тэрбум, 2017 онд 1.7 тэрбум, 2018 онд 1.8 тэрбум, 2019 онд 2.1 тэрбум, 2020 онд 2.5 тэрбум, 2021 онд 2.4 тэрбум, 2022-2023 онуудад 1.9 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байна. Актлагдсан хөрөнгө борлуулсан орлого 2023 онд 56.9 сая төгрөг байгаа нь өмнөх онуудаас 3 дахин бага төвлөрүүлсэн цаашид худалдан борлуулсан хөрөнгийн орлогод тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. |
| 3. | Арга хэмжээ 2.2 2.5.15.Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт тавих[7] | - | Санхүүжилтийн дүн, сая төгрөг Хэрэгжилтийн хувь | 18,699.9<br>100% | -<br>100% | Нийслэлийн Засаг даргын 2023-2024 оны эрх шилжүүлсэн захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт бүхий нийт **3** ажилд захиалагчийн хяналт тавин **33,155.0** мянган төгрөгийн санхүүжилтийг олгон, **87,2.0** мянган төгрөгийн хөрөнгийн худалдан авах гэрээний төслийг НЗДТГ-т хүргүүлсэн. : Үүнд:<br>- *Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1493 дугаар захирамжийн дагуу газрын даргын 2024 оны А/08 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг НХААГ/202412124 дугаартай гэрээний дагуу "Уаз Мега" ХХК-аас нийлүүлсэн ZVW30-1973547 арлын дугаартай 1790СС хөдөлгүүрийн хүчин чадалтай хабрид, урдаа FWD хөтлөгчтэй, жолооны хүрд баруун, 5 хүний суудалтай хар өнгийн суудлын 1 тээврийн хэрэгслийг Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүлээлгэн өгч 33,155,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон,*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/266 дугаар захирамжаар батлагдсан Налайх дүүргийн иргэдийн оролцоотойгоор агаар хөрсний бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд 3 настай алимын 1000 ширхэг суулгацыг худалдан авах НХААГ/20240202253 дугаартай 47,700,000 төгрөг, Налайх дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай автомашин худалдан авах (4, 6 дугаар хороо) НХААГ/20240202252 дугаартай 39,490,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон..*<br><br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2020-2023 онуудад, 2024 онд захиалагчийн хяналт тавьсан ажлын явцын тайлан мэдээг холбогдох хүснэгтийн дагуу 3 удаа хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 2.3 2.5.16.Өмнө онуудад хэрэгжин захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%-ийн барьцаа хөрөнгө болон чанарын баталгаат чөлөөлөх[6] | - | Санхүүжилтийн дүн, сая төгрөг Хэрэгжилтийн хувь | 34.5<br>100% | -<br>100% | Нийлүүлэгч компаниуд гэрээний үүргээ биелүүлж, баталгаат хугацаанд хэвийн ашиглаж байгаа тухай ашиглагч байгууллагын хүсэлтийг үндэслэн 5%-ийн барьцаа хөрөнгө **20,680.2 мянган** төгрөгийг чөлөөлсөн: Үүнд:<br>- *Хот байгуулалт, хөгжлийн газарт НХААГ/202004626 дугаар гэрээний дагуу нийлүүлсэн Хот байгуулалтын мэдээллийн сангийн тоног төхөөрөмжийн **8,892,783.5** төгрөг,*<br>- *Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т ГУББГ-09/2021 дугаар гэрээний дагуу нийлүүлсэн "Ус Зайлуулах насос" тоног **2,695,000** төгрөг,*<br>- *Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ-т ГУББГ-10/2021 дугаар гэрээний дагуу нийлүүлсэн "Бужигнуулагчтай лаг шаврын насос" тоног төхөөрөмж ийн **6,242,500** төгрөг*<br><br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Захиалагчийн хяналт тавьсан ажлын явцын тайлан мэдээг сар бүр холбогдох хүснэгтийн дагуу хүргүүлж ажилласан. |
| 5. | Арга хэмжээ 2.4 Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссын хуралд оролцож хяналт тавих[7] | - | Хөрөнгийн дүн, сая төгрөг Хэрэгжилтийн хувь | 63.8<br>100% | -<br>100% | Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын хурлын шийдвэрээр акталж данснаас хассан, татан төвлөрүүлж худалдан борлуулаагүй газрын даргын 2023 оны А тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж 420,055,970.2 төгрөгийн анхны бүртгэлийн үнэ бүхий 23 байгууллагын 69 нэр төрлийн хөрөнгийн жагсаалтыг гаргаж газрын даргад танилцуулсан.<br>ҮХХХК-ийн 12 удаагийн хурал зохион байгуулан нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой давхардсан тоогоор 455 байгууллагын хөрөнгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:<br>- Давхардсан тоогоор 78 байгууллагын 3,211.0 сая төгрөгийн үнэ бүхий гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүдээс хандивласан, төсөл хөтөлбөрөөр бий болсон тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэх мэт хөрөнгийг бүртгэх,<br>- Нийт 217 байгууллагын 25,501.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг акталж нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах,<br>- Нийт 84 байгууллагад 30,058.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг балансаас балансаас баланст шилжүүлэх,<br>-54 байгууллагын элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах 5,729.9 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлүүлэх,<br>-Данснаас дансанд шилжүүлсэн 22 байгууллагын 12,291.9 сая төгрөгийн хөрөнгө |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | Арга хэмжээ 2.5 3.1.8.Хяналт, шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, тухайн жилийн турш төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийх[8] | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу Хяналт шалгалтын 2024 оны 14 арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. |
| | *1. Хамтран ажиллах гэрээ, бусад баримт бичгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих* | - | - | - | - | *Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/287 дугаар захирамжаар нийслэлийн агаарын бохирдлын голомт, агаарын чанарыг сайжруулах I, II бүсийн айл өрхийг орон сууцаар хангах зорилтын хүрээнд ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг нь нийслэлийн төсвөөс төлсний дагуу эзэмших, өмчлөх эрх бүхий газраа нийслэлийн газрын санд шилжүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн газар эзэмших, өмчлөх эрхийг дуусгавар болгон "Нийслэлийн газрын сангийн удирдах хороо"-ны хурлаас гаргасан дүгнэлтийн дагуу дээрх 107 байршилд манай газарт эзэмших эрх олгосон. Дээрх 107 байршлаас 36 байршлыг "Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн газар чөлөөлөлтөд өртсөн иргэдэд эзэмшүүлэхээр шийдвэрлэж, одоогийн байдлаар НӨХГ нь 70 газар эзэмшиж байгаагаас Таван толгой түлш ХХК нь сайжруулсан түлш борлуулахад түүний зориулалтаар 56 байршил газрыг эзэмшиж байна. Газрын даргын 2024 оны А/34 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Хамтран ажиллах гэрээний "1.6-д тухайн газар дээр бүтээн байгуулсан барилга байгууламжийг газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ" гэж заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлш борлуулах газар дээр баригдсан байгууламжийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж байна. Тус газрын олон нийтэд үйлчлэх төв нийслэлд шилжин ирж байгаатай холбогдуулан ажил хүлээгдэж байна.* |
| | *2. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах талаар холбогдох нэгж,* | - | - | - | - | *Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн биелэлтийг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсээс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2 заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлтийг тайлант хугацаагаар буюу 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тооцсон болно. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлт* |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчдад зөвлөмж хүргүүлэх | | | | | бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 10 -100%, 1-66% (1 дэх), 3-0% (3,8,16 дахь) нийт 16 чиг үүргийн биелэлтийн дундаж 76.1% үнэлэгдлээ. |
| | 3. Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн байр талбайн болон хөрөнгийн эзэмшилт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд шалгалт хийх, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах | - | - | - | - | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", 65 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу 2024 оны №4/03 "Хяналт шалгалт хийх ажлын удирдамж"-ийг батлуулан Чингэлтэй, Сүхбаатар, Багануур, Багахангай дүүрэгт нийт 215 барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтын байдлыг газар дээр нь шалгасан. Шалгалтаар байр талбайд зөвшөөрөлгүй автомат машин, АТМ, киоск байршуулсан зөрчлийг арилгуулан 15 байгууллагад түрээсийн гэрээ, төлбөртэй холбоотой зөвлөмж хүргүүлэх, түрээсийн гэрээ байгуулан ажиллах, байр талбай чөлөөлөх, зөрчил арилгуулах зэрэг албан бичгийг хүргүүлсэн.<br>Налайх дүүргийн Эрдмийн оргил цогцолбор сургуулийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа Албан бус насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаанд шалгалт хийн сургуулийн орчинд хүнсний үйлдвэрлэл явуулж байгаа зөрчлийг арилгуулсан. Дүүргийн ЗДТГ-т Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6, Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн "Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага"-ын 10.1.2.-т заалтыг хэрэгжүүлэн ажиллан ерөнхий боловсролын дунд сургуулийн барилгын байр, талбайд бууз, банш, хэрчсэн гурил бэлтгэх, сургалт дадлагын төв ажиллуулах нь холбогдох хуульд нийцэхгүй хариу хүргэсэн.<br>НИТХ-ын 2021 оны А/466 дугаар тогтоолоор нийслэлийн өмчөөс хасахаар шийдвэрлэсэн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын нэр дээр бүртгэлтэй 1500600715 нэгж талбар бүхий газрын түүхчилсэн лавлагаа, мэдээллийг гаргуулж удирдлагад танилцуулсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/667 дугаар захирамжийн 1.3-т нийтийн бие засах газруудыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад түрээсээр ашиглуулах, зарим нийтийн бие засах газрын өмчийн харьяаллыг өөрчлөх, өргөтгөх чиглэлд дэмжлэг үзүүлж хамтран |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллахыг манай газарт даалгасан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийтийн тээврийн газар, Дижитал концепц ХХК-ийн 2023 онд байгуулсан №23/03-29 дугаартай Өмч ашиглалтын гэрээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Газрын тухай хууль, НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын заалтуудтай нийцэхгүй, гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэн түрээсийн гэрээ байгуулан ажиллахыг Дижитал Концепт ХХК-т мэдэгдсэн. Түрээсээр эзэмшиж байгаа 6 байршлыг газар дээр нь шалган Шархадны эцсийн буудалд байрлах барилгад зөвшөөрөлгүй үйл ажиллагааг зогсоохыг нийслэлийн Нийтийн тээврийн газарт мэдэгдсэн.<br>Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/336 дугаар захирамжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу:<br>- Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас худалдан борлуулсан хөрөнгийн 30% болох 29.0 сая төгрөг, бусад байгууллагын 4.7 сая төгрөг, нийт 43.7 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн<br>- Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын данснаас хасагдсан 5 тээврийн хэрэгсэл иргэний нэр дээр бүртгэлтэй хөдөлгөөнд оролцож байгааг тогтоон танилцуулсан.<br>- Авто тээврийн үндэсний төвд 2024 оны 02 дугаар сарын 28-ны 4/322 тоот лавлагаа мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсний бөгөөд Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ- данснаас хасагдсан 5 тээврийн хэрэгсэл иргэний нэр дээр бүртгэлтэй хөдөлгөөнд оролцож байгааг тогтоон танилцуулсан.<br>- Данснаас хасагдсан тээврийн хэрэгслүүдийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан орлогыг шүүн 1 тээврийн хэрэгсэл дутагдсаныг тогтоож холбогдох ТҮ-ий албан хаагчидтай сонсох ажиллагааг явуулан илрүүлж нийслэлийн төсөвт орлогыг төвлөрүүлсэн.<br>Нийслэлийн өмчит байгууллагуудын данснаас хасах тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааны анхны үнэ болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах үнэ тогтоох тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээ хийх сонгон шалгаруулах зарыг хэвлэл мэдээллээр нээлттэй мэдээлсэн. Газрын даргын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан комиссын бүрэлдэхүүн "Файн эстимэйт" ХХК-аас ирүүлсэн материалыг хянан хэлэлцээр хийж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 109 тээврийн хэрэгслээс 99 тээврийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгслийн үнэлгээг НЗДТГ-ын даргын А/159 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтэд туссан саналтай тулган нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөлд санал оруулсан.<br>Газрын даргын 2024 оны А/90 дүгээр тушаалаар байгуулсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлын хэсэгт орж батлагдсан удирдамжийн дагуу үнэлгээ өгөн, зөвлөмж хүргэн ажилласан. Үүнд:<br>- Баянзүрх дүүргийн төсөвт 4 байгууллага,<br>- Багахангай дүүргийн төсөвт 7 байгууллага,<br>- Багахангай дүүргийн 2 ОНӨТҮГ,<br>- Сүхбаатар дүүргийн төсөвт байгууллагууд<br>Газрын даргын 2024 оны А/77 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу Багануур дүүрэгт байрлах Хишиг Уул ХК-ийн (нийслэлийн мэдлийн 34% хувьцаа) үйл ажиллагаатай танилцан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын илэрсэн зөрчил, ажлын дүгнэлт бүхий тайланг удирдлагад танилцуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Татварын ерөнхий газарт Хишиг уул ХК-ийн татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтэд холбогдох хууль, журмын дагуу татварын хяналт шалгалт хийн, 2003-2023 оны санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгаас нийслэлийн мэдлийн 34 хувьд ногдол ашгийн хэмжээг тогтоон өгөх хүсэлтийг хүргүүлсний дагуу тус дүүргийн Татварын хэлтсийн 11 дүгээр сарын төлөвлөгөөнд тусгасан, шалгалтын дүнг НӨХГ-т ирүүлэхээр болсон.<br>Налайх дүүргийн төсөвт байгууллагын байр талбайн ашиглалтад хяналт шалгалт хийхэд 53 байгууллага, үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 15 байгууллага нь өөрийн байргүйгээс бусад байгууллагын байранд ашиглалтын гэрээ, хувийн хэвшлийн байранд түрээсийн гэрээгээр эзэмшин төрийн сангаас түрээсийн төлбөрт жилд 70.9 сая төгрөгийг зарцуулдаг байна.<br>Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн 0030УБО улсын дугаартай тээврийн хэрэгсэл балансаас балансд шилжүүлэн хүсэлтийн дагуу хөрөнгийг газар дээр нь үзэж НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 7.2.-т заасны актлах, шилжүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэрийн дагуу явагдах үйл ажиллагааг дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавихыг мэдэгдсэн.<br>Газрын даргын үүрэг болгосны дагуу нийслэлийн Засаг даргын 2024 оны тээврийн хэрэгсэл балансаас балансд шилжүүлэх тухай А/608 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар захирамжийн дагуу нийслэлийн Төр захиргааны бааз ОНӨТҮГ-ын балансд бүртгэлтэй 274.7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 8 тээврийн хэрэгслээс БГД-ийн ЗДТГ (1), БХД-ийн ЗДТГ (1), Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ (2), НӨХГ-т (1) зэрэг нийт 201.0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 5 тээврийн хэрэгслийг актаар хүлээлгэн өгсөн. (актыг ТЗБ-ын ашиглалтын инженер авсан болно.)<br>Нийслэлийн Төр захиргааны бааз ОНӨТҮГ-ын данснаас хасах бусад 36 тээврийн хэрэгсэлд "Мэдэгдэл", "Лац хөдлөхийг хориглосон" хуудсыг нааж НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 7.2.-т заасны актлах, шилжүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэрийн дагуу явагдах үйл ажиллагааг дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавихыг тус баазад мэдэгдсэн.<br>Газрын даргын 2024 оны А/245 дугаар тушаалаар "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ийн үйл ажиллага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийх ажлын удирдамжын дагуу 2024 оны 08 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд Сүхбаатар дүүрэг (Нийслэлийн өмчийн 1-р байр, 801 тоот) болон Сонгино хайрхан дүүрэг 32-р хороо, Бордооны хэсэг "Авто худалдааны цогцолбор"-т "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-ний одоогийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж дүгнэлтийг танилцуулсан.<br>Газрын даргын 2024 оны А/408 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт орж удирдамжийн дагуу Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын үйл ажиллагаанд шалгалт хийн ТУЗ, худалдан авах ажиллагаа, Өмч хамгаалан байнгын зөвлөл, хөрөнгийн хөдөлгөөн, түрээс, бусдад ашиглуулсан эзэмшил газартай холбоотой зөвлөмжийг хүргүүлсэн. Хүрээлэнгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын дүгнэлтээр түрээсийн орлогын 60 хувьд хамаарах өглөгийн үлдэгдэл болох 19,872,600.0 төгрөгийг төвлөрүүлэхийг мэдэгдсэн. |
| | 4. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хянал шалгалт | - | - | - | - | Нийслэлийн өмчийн түрээсийн гэрээ дүгнэх 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн №01 удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн 7, Сүхбаатар дүүргийн 4, Багахангай дүүргийн 4, Хан-Уул дүүргийн 6, Сонгинохайрхан дүүргийн 15, Налайх дүүргийн 2, нийт 80 байгуулагад хяналт шалгалт хийхэд түрээсийн төлбөр дутуу төвлөрүүлсэн, зөвшөөрөлгүй үүрэн холбооны төхөөрөмж, банкны АТМ байрлуулсан, хувийн хөрөнгөөр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хийх, гэрээний биелэлтийг дүгнэх | | | | | өргөтгөл барьсан зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэн ажилласан. Үүнд:<br>- 14 байр, талбайд түрээсийн гэрээ байгуулаагүй,<br>- 7 байгууллага түрээсийн үйл ажиллагаа явуулаагүй (СБД-ийн ЗДТГ-ийн Худалдаа хөгжлийн банк, В.Мөнхдалай цайны газар, СБД ЭМТ-ийн сувиллын цайны газар Цолмон маргад трейд ХХК, Тод онош ХХК, Сэрж мандах ХХК кофе шоп, ЧД Нандин гурван эрдэнэ ХХК цэцэрлэг, ЧДЭМТ Сэнгэ дөш өвчтөний гал тогоо),<br>- СБД-ийн 17 сургуулийн захирал нь түрээсийн цайны газартай (тусгай нөхцөлтэй, санхүүжилт хийх) нэмэлт гэрээ байгуулсныг илрүүлж, сургууль зөрчил арилгасан тухай 2024.02.29-ний өдрийн 602, 603 албан бичгээр ирүүлсэн.<br>- Хүрээ амаржих газрын цайны газар 2023 онд түрээсийн гэрээ байгуулах хүсэлтийг хүргүүлсэн боловч байгуулаагүй, өвчтөний цайны газрыг гадагшаа хаалга гаргасан зөрчил арилгуулан 2023 оны төлбөрийг нөхөн төлүүлж, гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн.<br>- Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, "Нүхэн гарц"-д үйл ажиллагаа явуулж байгаа иргэдээс түрээсийн гэрээ байгуулах, тус барилга, байгууламжийн ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр 20 иргэний өргөдлийн дагуу түрээслэгчдийн хүлээн авч уулзалт зохион байгуулан, тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын дагуу нийслэлийн өмчийн байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, түрээсийн гэрээ байгуулах ажиллахыг мэдэгдсэн. Үүний дагуу 20 иргэнтэй уулзаж, бүртгэл мэдээллийг шинэчилэн гэрээ байгуулах хүсэлт, мэдээллийг Захиргаа удирдлагын хэлтэст актаар хүлээлгэн өгсөн.<br>- Нийслэлийн Өмчийн харилцааны газарт мэдэгдэлгүйгээр дур мэдэн Баянгол дүүрэг, 8 хорооны нутаг дэвсгэрт байрлах (хуучин Аминжаргалан ӨЭМТийн ашиглаж байсан) нийслэлийн өмчийн барилгыг иргэн Б.Ганцогт, БГД-ийн ЗДТГ-ыг төлөөлж Аж ахуйн албаны дарга Ц.Энх-Амгалан нар нь 2023 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 203 дугаартай түрээсийн гэрээ байгуулж "Чин гэгээн өргөө" ӨЭМТ-д ашиглуулсан зөрчлийн дагуу өрхийн эмнэлгийн удирдлагатай уулзалт зохион байгуулан тус байрыг чөлөөлөхийг мэдэгдсэн. Барилгын ашиглалтын асуудлаар ИХАШШ-д нэхэмжлэл гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Чин гэгээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өрхийн эмнэлэг, БГД-ийн ЗДТГ-тай 2024.10.01-ний өдөр түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна.<br>- Байгууллагын 2023 онд байгуулсан гурвалсан 137 гэрээ, шууд 12 байр талбайн гэрээний алдангийн тооцоолол гарган танилцуулсан.<br>- НД-ийн ЗДТГ-ын төрийн сангийн хэлтэстэй уулзан хийн дүүргийн Налайх Хангамжийн төв 2023 оны түрээсийн үлдэгдэл 6.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.<br>- НСТӨ-ний "Г" корпуст байрлах иргэд, хуулийн этгээдийн 34 түрээсийн байр, талбайг газар дээр нь шалгасан судалгааг гарган хүргүүлсэн.<br>- Баянгол дүүргийн 14 дүгээр хороо, 3 дугаар хорооллын нутаг дэвсгэрт барлах хуучнаар "Монгол Шуудан" ХК-ийн 24 дүгээр салбар байрны түрээслэгч Тэмүүжин групп майнинг ХХК нь байр, талбайг дамжуулан түрээсэлсэн зөрчлийг арилган түрээсийн гэрээг дуусгавар болгох мэдэгдэл хүргүүлсэн. Түрээслэгч иргэд, аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэн, уулзалтыг зохион байгуулан сарын төлбөр 300.0-350.0 мянган төгрөгөөр түрээсийн гэрээ байгуулахаар хэлэлцээр хийсэн. |
| | 5. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комиссын шийдвэрээр түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа байр, талбайг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд шалгалт хийх | - | - | - | - | Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 2023 онд байгуулсан түрээсийн гэрээний алданги, 2024 оны түрээсийн байр талбайн орлогын төсөөллийг гарган танилцуулсан. Нийслэлийн өмчийн эд хөрөнгө түрээсийн гэрээний 4.7 заасны дагуу хожимдуулан төлсөн дүнгийн хоног тутам 0.5%-д алданги тооцвол 2023 онд 12.5 сая төгрөг байна. Түрээсийн байр талбайн судалгаагаар нийт 319 гэрээний 2,089.7 сая төгрөг төвлөрөх тооцоолол гарч энэ нь 2024 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 979.1 сая төгрөг дутуу, цаашид түрээсийн талбайн үнийг зах зээлтэй уялдуулан нэмэгдүүлэх, илүүдэлтэй байр талбайн хяналт шалгалтыг сайжруулан, гэрээгүй үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, ахуйн нэгжтэй түрээсийн гэрээ байгуулах зэрэг ажлыг зохион байгуулан ажилласан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| . | 6. 2023 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмжийн бүртгэлд хяналт тавих (Аудитын дүгнэлтэд хамрагдсан хөрөнгө) | - | - | - | - | Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 739 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нийт хэлтэст танилцуулсан. НӨХГ-т даалгасан 1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд үүссэн хөрөнгийг бүрэн хэмжээнд бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгуулах талаар арга хэмжээ авч ажиллах, 2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, өмчид бүртгэгдэхгүй хөрөнгийг цаашид хэрэгн бүртгэх талаар журамд тусгуулах талаар холбогдох байгууллагуудад санал боловсруулан хүргүүлж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхээр хүлээгдэж байна. |
| | 7. Түрээсийн орлого, ноогдол ашгийн орлого, бусад орлогын батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих | - | - | - | - | Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсээс сар бүр орлогын төлөвлөгөөний биелэлтийг хуснэгтийн дагуу авч дүн шинжилгээ хийсэн. Эхний хагас жилийн байдлаар түрээсийн орлого 2.6 тэрбум (94,7%), ногдол ашгийн орлого 2,7 тэрбум төгрөг (245,8%), актлагдсан хөрөнгө борлуулсан орлого 262,8 сая төгрөг (175,2%), нийт нийслэлийн төсөвт 6,3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 90,5%-ийн хэрэгжилттэй ажилласан байна.<br>НИТХТ-ын 2024 оны 97 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 9 үйлдвэрийн газрын 1,3 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр баталж гүйцэтгэлээр Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 450.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 160.0 сая төгрөг 35.5%, Улаанбаатар хотын даатгал 6.0 сая төвлөрүүлсэн байна.<br>Акталсан хөрөнгө, худалдан борлуулсан орлого болох 66.7 сая төгрөгийн орлогын 33.7 сая төгрөг 51%нь өмнөх онд худалдан борлуулсан тээврийн хэрэгслийн орлого байна.<br>Жилийн эцсийн байдлаар нийслэлийн төсвийн орлогын хуваарийн дагуу түрээсийн орлого, актлагдсан хөрөнгө борлуулсны орлого, аж ахуй нэгжийн ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 6,338.9 сая төгрөг, гүйцэтгэл өссөн дүнгээр 2024 оны 11 дүгээр 30-ны өдрийн байдлаар 6,324.7 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 105%-ийн хэрэгжилттэй ажилласан. Үүнд Түрээсийн төлөвлөгөө 3,068,9 сая төгрөг, биелэлт 2,609,6 сая төгрөг (95%), Ногдол ашгийн төлөвлөгөө 1,1200, сая төгрөг, биелэлт 2,753,0 сая төгрөг 245,8%, Актлагдсан хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө 150,000.0 сая төгрөг, биелэлт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 262,856.0сая төгрөг 175,2%,Өмч хувьчлалын төлөвлөгөө 2,000,0 сая төгрөг, биелэлт 699,210.0 (35,0%). |
| | 8.Байгууллагын Шилэн дансны мэдээлэл цахим хуудас, мэдээллийн самбарт хугацаанд нь үнэн зөв тавигдсан эсэхэд хяналт тавих | - | - | - | - | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан Монгол Улсын Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр шинэчилсний дагуу байгууллагын цахим хуудасны хугацаанд нь бөглөж хэвшсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажиллах хүрээнд байгууллагын Шилэн дансны хөтлөлтийг сар бүр хянаж, дутуу оруулсан биелэлтийг хугацаанд нь ажиллахыг санхүүгийн албан хаагчдад зөвлөмж хүргэн ажиллаж байна.<br>Эхний хагас жилд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг 100 хувь байршуулсан бөгөөд үүнээс төсвийн гүйцэтгэлийн 1, 2,8 дугаарт заасан тайланг хугацаанд нь мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээллээр 2024 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төсвийн 1,121,070,000 төгрөгөөс 872,899,000 төгрөгийн (72.1%) зардал гарган ажилласан байна.<br>Жилийн эцсийн байдлаар 2024 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар Шилэн дансанд нийт 153 мэдээллийг бүрэн үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулсан, 6 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан байна. Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн 84 мэдээлэл, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 33 мэдээлэл, Бусад 34 мэдээлэл байна. |
| | 9. Байгууллагын нээлттэй мэдээллийг байршуулж нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй хангах ажиллаж байгаад хяналт тавих | - | - | - | - | Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу байгууллагын цахим хуудасны 2023 оны мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийхэд дундаж гүйцэтгэл 65%-тай үнэлэгдэж мэдээг НЗТГТ-т хүргүүлсэн.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг харган ажиллах хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, бусад байгууллагад байгууллагын цахим хуудсанд дараах мэдээллийг нээлттэй байршуулсан байна.. Үүнд:<br>- Байгууллагын танилцуулга, хэлтсийн чиг үүрэг, утасны жагсаалт, цаг үеийн мэдээ мэдээлэл, барилга байгууламжийн дуудлага худалдаа, түрээсийн сонгоон шалгаруулалтын зар, урилга, тээврийн хэрэгслийн дуудлага худалдаа, эрх зүйн актууд, газрын даргын тушаал, хүний нөөцийн ил тод байдал, албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны сул орон тоо, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гишүүний мэдээлэл, төсөв санхүүгийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ил тод байдал, шилэн дансны мэдээлэл, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, төрийн үйлчилгээ цэсэд дуудлага худалдаанд оролцох хүсэлт, шинээр хөрөнгө худалдан авах, хандив ээл тусламжийн хөрөнгө бүртгэх, хөрөнгө данснаас хасах, түрээсийн гэрээний загвар, Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар, хавсралтууд, цаг үеийн холбоотой мэдээ, мэдээлэлүүд |
| | 10. Баримт бичгийн шийдвэрлэлт, хадгалалт, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих | - | - | - | | Газрын даргын баталсан 2024.01.22 оны "Баримт хүлээн авах хуваар"-ийн дагуу 2023 онд үүссэн Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн 152, Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн 41, Өмчийн менежментийн хэлтсийн 33, нийт 226 хадгаламжийн нэгжээр архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийг хийсэн байна. |
| | 11. Тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтэд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийн удирдлагыг мэдээллээр хангах | - | - | - | - | - Газрын даргын 2024 оны ажлын хэсэг байгуулах тухай 03 дугаар сарын 21-ний өдөр хүртэл 9 тушаалын хэрэгжилтийг ЗТСХ-ээс авч хянал-шинжилгээ, үнэлгээ хийн, 6 тушаалын хэрэгжилт 95% байна. Бусад үнэлгээнд хамрагдаагүй 3 ажлын хэсэг:<br>- Урт цагаан үйлчилгээний төвийг буулгах түр хашаа хүлээн авах ажлын хэсэг (А/10 тушаал),<br>- Соёлын төв өргөөний "Г" блокийн суларсан өрөө тасалгаа, талбайг "Албан тасалгаа"-ны зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс байгуулах (А/13),<br>- Шахмал түлшийг нөөцлөх болон борлуулах цэг"-ийн зориулалтаар 70 байршилд бүтээн байгуулсан барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хүлээн авах хүлээлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг (А/34).<br>Газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийг ажлын тайлан, холбогдох баримтыг байгууллагын архивт хүлээлгэн өгснөөр хэрэгжилт 100% хангагдах тухай мэдэгдсэн болно. Мөн цаг үеийн шаардлагаар ажиллаагүй ажлын хэсэг байгуулах тушаалыг удирдлагад танилцуулан хүчингүй болгох саналыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст мэдэгдсэн. |
| | 12. Чиг үүргийн хүрээнд хэлтэс, албан хаагчдын ажил, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн удирдлагад | - | - | - | - | Газрын даргын 2024 оны А/37 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт 2 албан хаагч оролцон нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулагдсан "Нийслэлийн өмчийн барилга байгууламж бүртгэх авах тухай" албан бичгээр илгээсэн асуудалд ӨМХ-ийн мэргэжилтэн О нь арифметикийн алдаа гаргасан эсэхийг тогтоож дүгнэлтийг удирдлагад |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | танилцуулах, зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлэх, зөрчлийн арга хэмжээний санал оруулах | | | | | танилцуулан Нийслэлийн Засаг даргын тамгын газарт тэмдэглэлийн хамт хүргүүлсэн.<br>Иргэн А.Туяагийн Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан ӨМХ-ийн мэргэжилтэн О-ийн ёс зүйн харьцаатай холбоотой гаргасан гомдлын дагуу холбогдох мэргэжилтэн Т-ээс хаагчаас тайлбар авч хариуг албан бичгээр хүргүүлсэн. |
| | 14. Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий албан тушаалтын шийдвэр, өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | - | - | - | - | Бат их эв бэлтгэл ажлын хэсгийн ерөнхий зохицуулах зөвлөл НҮТББ-аас ирүүлсэн 00/1363 албан бичгийн дагуу шалгахад "Ард" кинотеатрыг хувьчлалын материал нийслэлийн Архивын газарт шилжүүлсэн, архиваас 2023 онд ирүүлсэн мэдээллийг судалж хариуг хүргүүлсэн.<br>**<u>Төв цэнгэлдэх хүрээлэн ХК:</u>**<br>Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнгийн барилга байгууламжийн ашиглалтыг газар дээр нь шалгахад тус компани нь "Ажлын байрны зориулалтаар өрөөний түрээсийн гэрээ" байгуулан байр, талбайг иргэд, аж ахуйн нэгжид түрээслүүлэн үйл ажиллагаа явуулж байсан зөрчил илэрснийг Илтгэх хуудсаар танилцуулсан.<br>**<u>Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв (УАУЭСКТ):</u>**<br>Сүхбаатар дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн хуучин эмийн үйлдвэрийн барилга, байгууламжийг НИТХТ-ийн 2010 оны 87 дугаар тогтоолоор нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2010 оны 445 дугаар захирамжаар тус барилгыг данс бүртгэлээс хасаж, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар үнэлэн худалдаж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт даалгасны дагуу барилгын өрөө, гадна хаалганд "Мэдэгдэл", "Лац хөдлөхийг хориглосон" хуудсыг нааж, эмийн үйлдвэрлэл явуулж байгаа УАУЭСКТ-ийн байр чөлөөлөх мэдэгдэл хүргүүлсэн. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын дүрмийн шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон барилгад эмийн үйлдвэрлэл явуулж байсныг нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хяналт шалгалтын газарт гаргасан хүсэлтийн дагуу улсын байцаагч томилуулан Эрүүл мэндийн газрын Улсын байцаагчийн 2024 |
| | | | | | | оны 10-13-02/063/003 дугаар дүгнэлтээр 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түр зогсоон, Хяналт шалгалтын газрын Улсын ахлах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
